

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго, агуулга, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, харилцаанд оролцогчдын эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж

2.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Иргэн тасралтгүй сурч, боловсрох, хөдөлмөр эрхлэх ур чадвараа ахиулах насан туршийн суралцахуйн харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Энэ хууль нь мэргэжлийн боловсрол, сургалтыг зохион байгуулах өмчийн аливаа хэлбэрийн хуулийн этгээдэд хамаарна.

3.3.Иргэний албан бус хэлбэрээр эзэмшсэн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.4.Цэрэг, цагдаа, аюулгүй байдлыг хангах байгууллагын харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, боловсролын баримт бичиг олгох асуудлыг энэ хуулиар, бусад харилцааг тухайн салбарын хууль тогтоомжоор зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“чадамжид суурилсан сургалт” гэж ажил, мэргэжлийн стандартад заасан чадамжийг ажлын байранд хэрэглэх чадвар эзэмшүүлэх, тодорхой үр дүнд чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг;

4.1.2.“чадамж” гэж ажил үүргийг хөдөлмөрийн орчинд үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай, хэмжиж болохуйц мэдлэг, үр чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

4.1.3.“мэргэжил” гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах хоорондоо уялдаа бүхий чадамжийн цогцыг;

4.1.4.“мэргэшил” гэж тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах ахисан түвшний чадамжийг;

4.1.5.“үндэсний мэргэшлийн тогтолцоо” гэж мэргэшлийн талаар баримтлах бодлого, стратеги боловсруулалт, хэрэгжүүлэлт, санхүүжилт, албан ба албан бус суралцахуйг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах, боловсрол, сургалт, хөдөлмөрийн зах зээлийн нэгдмэл байдлыг хангах системийг;

4.1.6.“мэргэшлийн түвшин” гэж үндэсний мэргэшлийн хүрээн дэх мэргэжлийн боловсрол, сургалтад хамаарах мэргэшлийн шатлалыг;

4.1.7.“чанарын баталгаажилт” гэж мэргэжлийн боловсрол, сургалтыг стандартад нийцүүлэх, чанарыг тасралтгүй дээшлүүлэх, үр дүнг баталгаажуулахад чиглэсэн үйл ажиллагааны цогцыг;

4.1.8.“мэргэжлийн боловсрол, сургалт” гэж үр чадварын сургалт эрхлэх, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг;

4.1.9.“ур чадварын сургалт” гэж хувь хүний хэрэгцээнд нийцсэн, эсхүл ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах тодорхой ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх үйл ажиллагааг;

4.1.10.“мэргэжлийн боловсрол” гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээ шаардлагад нийцүүлж, зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, үр чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

4.1.11.“техникийн боловсрол” гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээ шаардлагад нийцүүлж, зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, үр чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

4.1.12.“мэргэшүүлэх сургалт” гэж мэргэжил эзэмшсэн иргэнийг давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх үйл ажиллагааг;

4.1.13.“чадамжийн нэгж” гэж тодорхой ажил, мэргэжлийн чадамж эзэмшүүлэхэд чиглэсэн харилцан уялдаа бүхий сургалтын нэгж ажилбарыг;

4.1.14.“чадамжийн үнэлгээ” гэж иргэний эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлох үйл явцыг.

5 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго, зарчим

5.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан шинжлэх ухаан, технологийн хөгжил, боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх, мэргэшүүлэх, хөдөлмөрийн соёлыг төлөвшүүлэхэд оршино.

5.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого, үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 5.2.1.иргэнд тэгш, хүртээмжтэй байх;
- 5.2.2.эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- 5.2.3.нээлттэй, тогтвортой, уян хатан байх;
- 5.2.4.нийгмийн түншлэлд суурилах;
- 5.2.5.насан туршийн суралцахуйг дэмжих.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН АГУУЛГА, СТАНДАРТ, ХӨТӨЛБӨР

6 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга

6.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга нь мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт болон чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр тодорхойлогоно.

6.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулга нь залгамж холбоотой байх бөгөөд дараах нийтлэг шаардлага тавигдана:

6.2.1.Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт зааснаас гадна мэдээллийн технологи, гадаад хэл, жендерийн тэгш байдал, гамшгаас хамгаалах болон байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх ногоон ур чадвар, хандлага, үнэт зүйлийг тусгах;

6.2.2.агуулгыг багц цагаар хэмжих бөгөөд шатлан суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор сургалтын зохих хөтөлбөрийг дараагийн шатны боловсролын агуулгатай уялдуулах.

6.3.Ур чадварын сургалтын агуулга нь тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах ур чадвар, бизнес, аж ахуй эрхлэх мэдлэг олгох, хувь хүний хэрэгцээнд нийцсэн чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

6.4.Мэргэжлийн боловсролын агуулга нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэх, өрсөлдөх, хөрвөх чадвартай, ёс зүйтэй, хариуцлагатай, мэргэжлийн боловсролтой иргэнийг бэлтгэх, бүрэн дунд боловсролыг хослуулан эзэмшүүлэхэд чиглэнэ.

6.5.Техникийн боловсролын агуулга нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, техник, технологийн мэдлэг, ур чадвар эзэмшсэн, асуудал шийдвэрлэх, өрсөлдөх чадвартай, бүтээлч, ёс зүйтэй, хариуцлагатай техникийн боловсролтой иргэнийг бэлтгэхэд чиглэнэ.

7 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт

7.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт нь ажил, мэргэжлийн стандартад нийцсэн байх ба мэргэшлийн харгалзах түвшинд боловсруулна.

7.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад дараах үзүүлэлт, шаардлагыг тусгасан байна:

7.2.1.тухайн мэргэжлийн ажил үүрэг, ажилбаруудад үндэслэн тодорхойлсон чадамжийн нэгжүүд бүхий сургалтын агуулга;

7.2.2.чадамжийн нэгж бүрээр тодорхойлсон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, чадамжийн нэгжийн болон төгсөлтийн хөндлөнгийн үнэлгээ;

7.2.3.мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад элсэгчид энэ хуульд заасны дагуу тавигдах нийтлэг болон тусгай шаардлага;

7.2.4.багшид энэ хуульд заасны дагуу тавигдах нийтлэг болон тусгай шаардлага;

7.2.5.мэргэжлийн онцлогоос хамаарсан сургалтын танхим, лаборатори, дадлагын газар, машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг байгальд ээлтэй, ногоон сургалтын орчин;

7.2.6.холбогдох хууль тогтоомжид заасан бусад үзүүлэлт, шаардлага.

7.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартчиллын техникийн хороо нь мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллага, холбогдох эрх бүхий төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, иргэн, ажил олгогч, мэргэжлийн холбооны төлөөллөөс бүрдэнэ.

7.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1-д заасны дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын стандартчиллын техникийн хороо боловсруулж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан байгууллага батална.

7.5.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх ажлыг зохион байгуулна.

7.6.Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг боловсруулна.

8 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр

8.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр /цаашид “сургалтын хөтөлбөр” гэх/ мэргэшлийн түвшин бүрд тохирсон, мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад нийцсэн байх бөгөөд хоорондоо уялдаа холбоо бүхий сургалтын агуулга, төлөвлөгөө, багшлах болон суралцах үйл ажиллагаа, арга зүй, үнэлгээ, зохион байгуулалтыг тодорхойлсон баримт бичиг байна.

8.2.Сургалтын хөтөлбөрийн агуултыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэнэ.

8.3.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлага, загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

8.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг энэ хуулийн 8.3-т заасан нийтлэг шаардлага, загварт нийцүүлэн ажил олгогч, нийгмийн түншлэлийн оролцоотойгоор боловсруулж, захирал батална.

8.5.Мэргэжлийн боловсролын сургалтыг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалттай хослуулан зохион байгуулах тохиолдолд Бага, дунд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зорилтод нийцүүлэх бөгөөд бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн заавал судлах агуулгыг боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

8.6.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага сургалтын хөтөлбөрөө олон улсын жишиг, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагын өөрчлөлтөд нийцүүлэн тасралтгүй сайжруулах бөгөөд гадаад, дотоодын боловсролын байгууллагатай хамтарсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж болно.

8.7.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага хэрэгжүүлнэ.

8.8.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.

9 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын зохион байгуулалт

9.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтыг танхимын, танхимын бус, дадлагыг сургалтын болон үйлдвэрлэлийн хэлбэрээр зохион байгуулна.

9.2.Үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг аж ахуйн нэгж, суралцаач, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дагалдан суралцаах гурван талт гэрээ байгуулж ажлын байранд зохион байгуулна.

9.3.Үйлдвэрлэлийн дадлагад тавигдах шаардлага, зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар: Танхимын бус сургалтад зайны болон цахим, эчнээ сургалтыг хамаарч ойлгоно.

10 дугаар зүйл.Боловсролын баримт бичиг

10.1.Боловсролын баримт бичиг нь тухайн иргэний эзэмшсэн мэргэжил, боловсролын агуулгын түвшинг гэрчилнэ.

10.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг албан болон албан бусаар эзэмшиж үнэлгээнд тэнцсэн иргэнд дараах боловсролын баримт бичгийг олгоно:

10.2.1.мэргэшлийн тодорхой түвшний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдаж чадамж эзэмшсэн иргэнд чадамжийн гэрчилгээ;

10.2.2.суурь боловсролтой иргэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж, мэргэжил болон бүрэн дунд боловсролыг хамтад нь эзэмшсэн бол мэргэжлийн боловсролын үнэмлэх;

10.2.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж мэргэжил эзэмшсэн бол мэргэжлийн үнэмлэх;

10.2.4.бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой иргэн техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж техникийн боловсрол эзэмшсэн бол техникийн боловсролын диплом;

10.3.Иргэний албан бус хэлбэрээр эзэмшсэн чадамжийн цогцыг үнэлж, баталгаажуулсан үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын дүгнэлтийг үндэслэн зохих түвшний баримт бичгийг мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага олгоно.

10.4.Мэргэжлийн боловсролын үнэмлэхийн загвар, баримт бичиг бүрдүүлэх, шинээр болон нөхөн олгох, лавлагаа мэдээллээр хангах журмыг боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.5.Мэргэжлийн боловсролын үнэмлэхээс бусад мэргэжлийн болон техникийн боловсролын баримт бичгийн загвар, баримт бичиг бүрдүүлэх, олгох журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6.Иргэн, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид боловсролын баримт бичиг олгох асуудлыг энэ хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

11 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаа, хэв шинж

11.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага дараах үйл ажиллагааг дангаар, эсхүл хослуулан эрхэлнэ:

- 11.1.1.ур чадварын сургалт;
- 11.1.2.мэргэжлийн боловсрол;
- 11.1.3.техникийн боловсрол.

11.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөгжлийн бодлого, эдийн засгийн бүтэц, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл, бүсчилсэн хөгжлийг харгалзан мэргэжлийн чиглэлээр сургалт, үйлдвэрлэлийн үлгэр жишээ орчин бүхий жишиг цогцолбор, салбар дундын дадлагын бааз, чадамжийн төв, хотхон байдлаар төрөлжүүлж болно.

11.3.Чадамжийн төв мэргэжлийн багшийг чадавхжуулах, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтныг мэргэшүүлэх, албан бус хэлбэрээр эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлэх, судалгаа, шинжилгээ, инновацийг хөгжүүлэх, мэргэжлийн тэмцээн зохион байгуулах, мэргэшлийн ахисан түвшний сургалт эрхлэх үндсэн чиг үүрэгтэй байна.

11.4.Чадамжийн төв байгуулах шалгуур үзүүлэлт, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь дараах хэв шинжтэй байна:

11.5.1.техникийн боловсролын сургалтын байгууллага нь политехник коллеж байна;

11.5.2.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна;

12 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгах

12.1.Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

12.2.Орон нутгийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт заасан этгээд шийдвэрлэнэ.

12.3.Хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг үүсгэн байгуулагч шийдвэрлэнэ.

12.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

12.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын дэргэдэх мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд энэ хуулийн 3.4-т заасан сургалтын байгууллагад хамаарахгүй.

12.6.Гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан, нэрэмжит төрийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах асуудлыг холбогдох гэрээ, хэлэлцээр, баримт бичгийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

12.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага татан буугдсан тохиолдолд суралцагчийг ижил төстэй сургалтын байгууллагад шилжүүлэн суралцуулах, бусад харилцааг зохицуулах асуудлыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

12.8.Татан буугдсан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулах хугацаандаа гаргасан тушаал, шийдвэр, суралцагчдын нэрс, төгсөгчдийн боловсролын баримт бичгийн хуулбар, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох бичиг баримтыг татан буугдах шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

12.9.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт явуулах, олон улсын хөтөлбөртэй болон гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

асуудлыг Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

12.10.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.9-д заасан тусгай зөвшөөрлийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

12.11.Тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ:

12.11.1.сургалтын байгууллага байгуулах тухай үүсгэн байгуулагчийн өргөдөл, судалгаа, үндэслэл бүхий танилцуулга;

12.11.2.багш, хүний нөөцийн судалгаа;

12.11.3.сургалт явуулах барилга байгууламж, эзэмшил газрын зөвшөөрөл, сургалтын орчин, техник хэрэгсэл, ном, сурх бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа;

12.11.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа;

12.12.Сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгох журам, бүрдүүлэх бичиг баримтын загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.13.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага тусгай зөвшөөрөлд тусгагдсан мэргэжлийн чиглэлээр эрхэлж болно.

12.14.Ур чадварын сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин

13.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага сургалтын орчны стандартын шаардлага хангахаас гадна туршилт-үйлдвэрлэлийн цех, багшийн хөгжлийн төв, номын сан, дотуур байр, соёл-спортын болон мэдээллийн төвтэй байна.

13.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлдвэрлэл-үйлчилгээ эрхлэх нэгж, гарааны бизнес инкубатор, туслах аж ахуйтай байж болно.

13.3.Ур чадварын сургалтын байгууллага энэ хуулийн 12.14-т заасан журмын дагуу сургалтын орчинг бүрдүүлнэ.

13.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохирох хүртээмжтэй орчинг бүрдүүлнэ.

14 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эрх, үүрэг

14.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дараах эрхтэй:

14.1.1.хууль тогтоомжийн дагуу бие даасан байдлаа хангах;

14.1.2.суралцагч, багш, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

14.1.3.төрийн өмчийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжил, бүрэн дунд боловсролыг хослуулан олгодог сургалтаас бусад сургалтыг зохион байгуулахдаа удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр суралцагчдаас сургалтын төлбөр авах;

14.1.4.суралцагчийн сурлагын амжилт, мэргэшлийн ур чадварыг ажил олгогчид мэдээлэх, дадлагажуулах, төгсөгчийн сонирхолд тулгуурлан ажлын байранд зуучлах;

14.1.5.үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын түшиц газар хэлбэрээр ажиллуулах.

14.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дараах үүрэгтэй:

14.2.1.сургалтын байгууллагыг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай үйлчилгээ үзүүлэх;

14.2.2.дотоод чанарын баталгаажилтын механизм бүрдүүлэх, сургалтын хөтөлбөр, багшлахуй болон суралцахуйн явц, үр дүн, үйл ажиллагаандaa тогтмол үнэлгээ хийх, түүнд нийцүүлэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг тасралтгүй хянаж сайжруулах;

14.2.3.багш, ажилтан, суралцагч үр бүтээлтэй ажиллах, сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, тэднийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

14.2.4.хүүхэд, залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хөтөлбөрийг дангаар болон ерөнхий боловсролын сургуультай хамтран зохион байгуулах;

14.2.5.төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламжид хамрагдах тохиолдолд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөх;

14.2.6.сургалтын байгууллага түүний үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг энэ хуулийн 31.4-т заасан журмын дагуу мэдээллийн нэгдсэн санд байршуулах;

14.2.7.төгсөгчийг ажлын байртай болгоход аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах;

14.2.8.шашны чиглэлээр сургалт, зан үйл, бусад үйл ажиллагааг явуулахгүй байх;

14.2.9.жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.

15 дугаар зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын санхүүжилтийн гэрээ байгуулах

15.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай санхүүжилтийн гэрээ байгуулна.

15.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх санхүүжилтийн гэрээ байгуулах, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг санхүү, төсвийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

15.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын санхүүжилтийн гэрээнд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, санхүүжүүлэх зардлын хэмжээ болон гэрээний хугацаа, талуудын хүлээх үүрэг, хариуцлага, гэрээг цуцлах нөхцөлийг тодорхой тусгасан байна.

16 дугаар зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцагч элсүүлэх

16.1.Иргэнийг эзэмшсэн боловсрол, ур чадварын түвшин, хэрэгцээ, сонирхолд үндэслэн дараах сургалтын байгууллагад элсүүлнэ:

16.1.1.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын сургалтыг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалттай хослуулах сургалтад суурь боловсролтой иргэнийг;

16.1.2.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтад насанд хүрсэн иргэнийг боловсролын түвшин харгалзахгүй;

16.1.3.техникийн боловсролын сургалтын байгууллагын техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтад бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэнийг.

16.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, Үндэсний зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг элсүүлэн суралцуулж болох бөгөөд сургалтын төлбөрийн хэмжээг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөл тогтооно.

16.4.Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэх бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн судалгааны асуудал хариуцсан байгууллага гаргана.

16.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.6.Удирдах зөвлөл үлгэрчилсэн журамд нийцүүлэн суралцагч элсүүлэх журмыг баталж, захирал хэрэгжилтийг хангана.

17 дугаар зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалт

17.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлагыг Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын удирдах зөвлөл

18.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ үүсгэн байгуулагчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх гурван гишүүн, түншлэгчийг төлөөлөх гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

18.2.Удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах нийтлэг шаардлага, гишүүнийг батламжлах, чөлөөлөх, даргыг томилох зэрэг асуудлыг зохицуулсан дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.3.Дээд боловсролын сургалтын байгууллагын дэргэдэх мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийг энэ хуульд заасны дагуу байгуулна.

18.4.Хувийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд энэ хуулийн 18.1-д зааснаас гадна суралцагч, төгсөгчийн төлөөллийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр оролцуулж болно.

18.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар нэр дэвшүүлнэ:

18.5.1.төрийн болон орон нутгийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хувьд үүсгэн байгуулагчийг төлөөлөх гурван гишүүнийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас нэг, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг, нутгийн өөрөө удирдах байгууллагаас нэг хүнийг;

18.5.2.хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хувьд үүсгэн байгуулагч нь өөрийн төлөөлөх гурван гишүүнийг;

18.5.3.сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх гурван гишүүнийг тухайн хамт олны олонхын төлөөлөл оролцсон ирцтэй хурлаас багшийн төлөөллөөс хоёр хүнийг, ажилтны төлөөллөөс нэг хүнийг;

18.5.4.түншлэгчийг төлөөлөх гурван гишүүнийг тухайн сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч нь түншлэгч ажил олгогчийн төлөөлөл хоёр, мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл нэг хүнийг захирлын санал болгосноор.

18.6.Төрийн болон орон нутгийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүнийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хувийн өмчит мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүнийг тухайн сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч шууд батламжилна.

18.7.Удирдах зөвлөлийн гишүүний болон даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд даргыг үүсгэн байгуулагчийн төлөөллөөс олонхын саналаар сонгоно.

18.8.Удирдах зөвлөлийн дарга, гишүүн доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

18.8.1.энэ хуулийн 18.11-т заасан урамшууллаас гадна албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас шууд буюу шууд бусаар бэлэг, үйлчилгээ, мөнгөн орлого, зээл, тусламж авах, хөнгөлөлт эдлэх;

18.8.2.тухайн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нэгдмэл сонирхолтой этгээдийг санал болгох, захиалгын нийлүүлэгчээс ашиг авах;

18.8.3.гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох.

18.9.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байх бөгөөд гурван сар тутамд нэгээс доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг Удирдах зөвлөлийн дарга, эсхүл таваас доошгүй гишүүний санал болгосноор хуралдуулна.

18.10.Удирдах зөвлөлийн гишүүний урамшуулал, зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг тухайн сургалтын байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

18.11.Удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журмыг санхүү, төсвийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.12.Удирдах зөвлөл дараах эрх, үүрэгтэй:

18.12.1.мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлоготой нийцүүлж сургалтын байгууллагыг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг батлах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;

18.12.2.сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, төсвийн хуваарилалтыг батлах, хяналт тавих;

18.12.3.төсвийн хязгаарт нийцүүлэн сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;

18.12.4.сургалтын байгууллагад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, хяналт тавих;

18.12.5.сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, сургалтын үр дүн, чанар, гүйцэтгэлийг хэлэлцэх, үнэлэх, дүгнэх;

18.12.6.сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх, урамшуулах;

18.12.7.аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусlamжийн зарцуулалтыг хэлэлцэж, хэрэгжилтэд хяналт тавих;

18.12.8.шаардлагатай гэж үзвэл сургалтын байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэлд мэргэжлийн байгууллага, шинжээчээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэх;

18.12.9.захирлын хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас сургалтын байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх;

18.12.10.хууль тогтоомжид заасан бусад.

19 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага

19.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг тухайн байгууллагын захирал хэрэгжүүлнэ.

19.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлын албан тушаалын тодорхойлолтыг баталж, хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

19.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг таван жилийн хугацаагаар томилох бөгөөд ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн дахин нэг удаа улируулан томилж болно.

19.4.Энэ хуулийн 19.6.1-д заасан гэрээний үлгэрчилсэн загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд Удирдах зөвлөлийн дарга, захирал гэрээг байгуулж, гэрээнд энэ хуульд зааснаас бусад эрх, үүрэг, хүлээх хариуцлага, цалин хөлс, урамшуулал, холбогдох асуудлыг тусгана.

19.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал дараах нийтлэг эрхтэй:

19.5.1.багш, ажилтныг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах;

19.5.2.Удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хуваарийн дагуу тухайн сургалтын байгууллагын төсвийг захиран зарцуулах;

19.5.3.үйл ажиллагааны өөрийн орлогоо захиран зарцуулах;

19.5.4.Удирдах зөвлөлөөс тогтоосон цалингийн санд багтаан ажилтны ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, ажилтны нийгмийн баталгааг хангах;

19.5.5.Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах зэргээр тухайн сургалтын байгууллагыг төлөөлж үйл ажиллагаа явуулах;

19.5.6.хууль тогтоомж, журамд заасан бусад.

19.6.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын захирал дараах нийтлэг үүрэгтэй:

19.6.1.Удирдах зөвлөлтэй гэрээ байгуулан ажиллах;

19.6.2.сургалтын байгууллагыг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

19.6.3.нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

19.6.4.батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах;

19.6.5.хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, статистикийн мэдээ гаргах, мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

19.6.6.багш, ажилтныг чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

19.6.7.суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх;

19.6.8.төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах;

19.6.9.холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан бусад үүрэг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД

20 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын багш

20.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын багш дор дурдсан ерөнхий шаардлагыг хангана:

20.1.1.ур чадварын сургалтын багш тухайн мэргэжлийн чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээнд ажилласан туршлагатай, сургах зүйн чадамж эзэмшсэн;

20.1.2.мэргэжлийн боловсролын багш бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, баглах эрхтэй, эсхүл үйлдвэрлэлд ажилласан туршлагатай, мэргэшлийн өндөр ур чадвартай, баглах эрхтэй;

20.1.3.техникийн боловсролын багш магистр зэрэгтэй, үйлдвэрлэлийн болон судалгаа, шинжилгээний арга зүйн дадлага туршлагатай, баглах эрхтэй;

20.1.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах багш хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон арга зүй эзэмшсэн байх;

20.1.5.бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ерөнхий эрдмийн багш бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, баглах эрхтэй.

20.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын багш Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасан болон дараах эрхтэй:

20.2.1.үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн дагуу гэрээгээр ажиллах, мэргэшил дээшлүүлэх, зөвлөгөө өгөх;

20.2.2.шинэ техник, технологи эзэмших, дадлага хийх;

20.2.3.бүтээлийн чөлөө авах;

20.2.4.заах аргач багш, тэргүүлэх багш, зөвлөх багшийн мэргэшлийн зэрэг авах.

20.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын багш Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт заасан болон дараах үүрэгтэй:

20.3.1.мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх, суралцагчид мэргэжил, мэргэшлийн ур чадвар эзэмшүүлэх, сургалтын чанартай үйлчилгээ үзүүлэх;

20.3.2.сургалтын идэвхтэй, шинэлэг арга зүйг эзэмших;

20.3.3.сургалтын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллах;

20.3.4.мэргэжлийн багш аж ахуйн нэгж, байгууллагад жил бүр дадлагажиж, мэргэшлийн ур чадвараа ахиулах;

20.3.5.инноваци, шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, гадаад хэл, цахим ур чадварт суралцах, сургалтад нэвтрүүлэх;

20.3.6.хоёр жил тутамд мэргэшүүлэх сургалтад хамрагдах, гурван жил тутамд мэргэшил, ур чадвараа үнэлүүлэх;

20.3.7.багшийн ёс зүйн дүрмийг баримтлах;

20.3.8.сургалтын байгууллага болон багш, суралцагчийн сургалтын ажил, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, хориглоход биечлэн оролцох.

20.4.Багш, ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

20.4.1.хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, төлбөр, ажлын гүйцэтгэлд суурилсан урамшуулал авах, холбогдох хууль тогтоомжид заасан бусад хөнгөлөлт эдлэх;

20.4.2.хөдөлмөрийн онцлогийг харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, дэд захирал, сургалтын менежер, арга зүйч ажлын 15, багш, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно.

20.4.3.Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.5, 79.6 дахь хэсэгт заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан бусад нэмэгдэл амралт дээрх албан тушаалтанд хамаарахгүй;

20.4.4.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, сургалтын менежер, арга зүйч-багш Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасан баталгаа болон мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй ажилласан таван жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн сургалтын байгууллага олгох;

20.4.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, номын санч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч, дотоод чанарын

баталгаажилт, статистик хариуцсан ажилтан, эмчид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй ажилласан таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгох.

20.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

20.6.Багшлах эрх олгох, хүчингүй болгох журам, багшийн сургалтын ажлын ачаалал, багц цаг тооцох журам, багшийн мэргэшлийн ур чадварын түвшин тогтоох, үнэлэх журам, багшид мэргэшлийн зэрэг олгох журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын суралцагчийн эрх, үүрэг, нийгмийн баталгаа

21.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасан болон дараах эрхтэй:

21.1.1.сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглах;

21.1.2.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгч дараагийн шатны боловсрол, сургалтын байгууллагад суралцах;

21.1.3.үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад үйлдвэрлэлийн дадлага хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоонд ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх.

21.2.Боловсролын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасан болон дараах үүрэгтэй:

21.2.1.сургалтын орчин дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг баримтлах;

21.2.2.үйлдвэрлэлийн дадлагын үед аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг баримтлах, энэ хуулийн 9.2-т заасан гурван талт гэрээг сахин биелүүлэх.

21.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт заасан болон дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

21.3.1.Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.10-т заасан Засгийн газраас тогтоосон, хэмжээ, журмын дагуу сар тутам тэтгэлэг авах;

21.3.2.техникийн боловсролын сургалтын байгууллага төгсөгч багц цагийг хууль тогтоомж, холбогдох дүрэм, журамд заасны дагуу дүйцүүлэн тооцуулж дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах.

21.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага суралцагчийн хөгжил, хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

22 дугаар зүйл.Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг

22.1.Эцэг эх, асран хамгаалагч нь Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан болон дараах эрхтэй:

22.1.1.хүүхдийнхээ сурлага, төлөвшлийн талаар багш, удирдлагатай санал бодлоо солилцох, мэдээлэл авах;

22.1.2.ёс зүйн асуудлаар санал хүсэлтээ илэрхийлэх, шийдвэрлүүлэх;

22.1.3.хууль тогтоомжид заасан бусад эрх.

22.2.Эцэг эх, асран хамгаалагч нь Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасан болон дараах үүрэгтэй:

22.2.1.сургалт, дадлагын үйл ажиллагаатай танилцах, эргэх холбоотой ажиллах;

22.2.2.нийгэм, соёл, хүмүүжлийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

22.2.3.хүүхдийнхээ суралцах, мэргэжил өзэмших үйл ажиллагаанд байнга хяналт тавих;

22.2.4.гэр бүлийн орчинд бие даан суралцах нөхцөлийг бүрдүүлэх;

22.2.5.мэргэжлийн ур чадварын уралдаан, тэмцээнд идэвхтэй оролцуулах, дэмжих;

22.2.6.сургалтын байгууллагын орчноос гадуурх нийгмийн харилцаанд оролцох үйл явцад хүүхдэдээ анхаарал халамж тавих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

22.2.7.хүүхдийнхээ авьяас, мэргэшлийн ур чадварыг нээн хөгжүүлэх;

22.2.8.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

23 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

23.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах эрхтэй:

23.1.1.мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих, сургалтын байгууллагыг бэхжүүлэх, сургалтын орчин бүрдүүлэх, шинэчлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

23.1.2.сургалтын стандарт, хөтөлбөрийг боловсруулахад оролцох, сайжруулах талаар санал өгөх;

23.1.3.энэ хуульд заасны дагуу үйлдвэрлэлийн дадлага, төгсөлтийн үнэлгээг зохион байгуулахад хамтран ажиллах;

23.1.4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-15.1.6, 15.1.9-д заасан зардал, дэмжлэг, хандив, хөрөнгийн зардлыг албан татвар ногдох орлогоос хасуулах;

23.1.5.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд энэ хууль заасан журмын дагуу төлөөллөө оролцуулах;

23.1.6.иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох болон ажилтны мэргэшил дээшлүүлэх, мэргэшлийн ур чадвар эзэмшүүлэх чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах;

23.1.7.иргэний дур сонирхол, чадавх, боломжид нийцүүлэн мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх;

23.1.8.үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хамтран явуулах;

23.1.9.багш, инженер-техникийн ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, багшийг үйлдвэрлэлийн шинэ техник технологи дээр дадлагажуулах.

23.2.Аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэгтэй:

23.2.1.мэргэжилтэн бэлтгэх, мэргэшил дээшлүүлэхтэй холбогдсон мэдээлэл, захиалгыг мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн нэгдсэн санд байршуулах;

23.2.2.үйлдвэрлэлийн дадлагын дагалдан суралцах гурван талт гэрээг үндэслэн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлийн дагуу, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийг хүлээн авч үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, боломжоор хангах, үр дүнг хамтран дүгнэх;

23.2.3.үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулах, мэргэшлийн ур чадвар эзэмшүүлэх үүрэг бүхий дадлагажуулагч инженер-техникийн ажилтан ажиллуулах;

23.2.4.үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулахдаа дагалдан суралцах гурван талт гэрээ байгуулах бөгөөд гүйцэтгэсэн үүрэгт нь дүйцэхүйц цалин хөлсийг олгох.

ТАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН
ТОГТОЛЦОО

24 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулалтын тогтолцооны бүрэлдэхүүн

24.1.Иргэний мэргэшлийн ур чадвар, ажил олгогчийн шаардлагыг хангахад чиглэсэн сургалтын үр дүн, чанарыг тасралтгүй сайжруулах үндсэн хэрэгсэл нь мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулалтын тогтолцоо /цаашид “chanaryn баталгаажуулалтын тогтолцоо” гэх/ байна.

24.2.Чанарын баталгаажуулалтын тогтолцоог дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

- 24.2.1.мэргэшлийн баталгаажуулах;
- 24.2.2.тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих;
- 24.2.3.аттестатчилах;
- 24.2.4.магадлан итгэмжлэх;
- 24.2.5.гүйцэтгэлийг үнэлэх;
- 24.2.6.боловсролын баримт бичиг олгох.

25 дугаар зүйл.Мэргэшлийг баталгаажуулах

25.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэшлийн хэрэгцээ, уялдаа холбоо, давхардал, түвшний нийцлийг салбарын болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн баталгаажуулалтыг хийнэ.

25.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн нэр, индексийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ ур чадвар, мэргэжлийн чиг хандлагын талаарх мэдээллийг жил бүр олон нийтэд мэдээлнэ.

26 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих

26.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг энэ хуулийн 12.9, 12.10-д заасны дагуу зохицуулна.

27 дугаар зүйл.Аттестатчилах

27.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтын хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хяналтын болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн дагуу аттестатчилан хянана.

27.2.Аттестатчилах үйл ажиллагааг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад дөрвөн жил тутам нэг удаа зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд сургалтын байгууллагын үйл ажиллагааны тодорхой чиглэлээр аттестатчиллыг тухай бүр зохион байгуулж болно.

27.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг аттестатчилах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28 дугаар зүйл.Магадлан итгэмжлэх

28.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын тухай хуульд заасны дагуу сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлж болно.

29 дүгээр зүйл.Гүйцэтгэлийг үнэлэх

29.1.Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтын үр дүн, чанар, гүйцэтгэлийг суралцагч, төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, боловсролын баримт бичиг олгох хэлбэрээр үнэлнэ.

29.2.Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллага мэргэшлийн тодорхой түвшний үр чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдсан, эсхүл тухайн үр чадварыг албан бус хэлбэрээр эзэмшсэн иргэнийг чадамжийн гэрчилгээ олгох хэлбэрээр үнэлнэ.

29.3.Иргэн, суралцагч, төгсөгчийн чадамжийг үнэлэх, дүгнэлт гаргаж баталгаажуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад үнэлэхдээ энэ хуулийн 29.3-т заасан журмын дагуу сургалтын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ.

30 дугаар зүйл.Боловсролын баримт бичиг олгох

30.1.Боловсролын баримт бичиг олгох үйл ажиллагааг энэ хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

31 дүгээр зүйл.Мэдээллийн нэгдсэн сан

31.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/ нь сургалт, судалгаа, шинжилгээ, үнэлгээ, мэдээ, тайлан, хяналт, зохицуулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлага, үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулах бөгөөд төр, иргэд, аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, олон нийтэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

31.2.Мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрээр бүрдүүлж, хөгжүүлнэ.

31.3.Мэдээллийн нэгдсэн сан нь хөдөлмөрийн цахим бирж болон төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд салбар дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулж болно.

31.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

32 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо

32.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо нь мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагаас бүрдэнэ.

33 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын нийгмийн түншлэл, үндэсний зөвлөл

33.1.Нийгмийн түншлэлийг үндэсний хэмжээнд Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/, салбар, орон нутагт салбарын болон мэргэжлийн зөвлөл, сургалтын байгууллагад Удирдах зөвлөл тус тус бүрдүүлнэ.

33.2.Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх чиглэлээр нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч хамтран нийгмийн түншлэлийн оролцоог хангана.

33.3.Үндэсний зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг гүйцэтгэх бөгөөд мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага байна.

33.4.Засгийн газар Үндэсний зөвлөлийн дүрмийг баталж, гишүүнийг томилно.

33.5.Үндэсний зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна:

33.5.1.Засгийн газрыг төлөөлж мэргэжлийн боловсрол, сургалтын, эрчим хүчний, барилгын, зам, тээврийн, уул уурхай, хүнд үйлдвэрийн, хүнс, хөдөө

аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн;

33.5.2.хувийн хэвшил, ажил олгогчдын төлөөллийн байгууллага, томоохон аж ахуйн нэгж, байгууллага, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээс зургаан хүн;

33.5.3.төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн нэгдсэн холбоодоос гурван хүн.

33.6.Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхтэй:

33.6.1.мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хэлэлцэх, санал, дүгнэлт гаргах;

33.6.2.мэргэжлийн боловсрол, сургалтад төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах;

33.6.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад тухайн жилд суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоог хэлэлцэн дүгнэлт гаргаж мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

33.6.4.мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар илтгэл, мэдээлэл хэлэлцэх, зөвлөмж гаргах;

33.6.5.салбарын зөвлөл боловсруулсан ажил, мэргэжлийн стандартыг батлах;

33.6.6.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

33.6.7.мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох эсэх асуудлаар санал гаргах;

33.6.8.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд аж ахуйн нэгж, байгууллагаас үзүүлж болох санхүүгийн дэмжлэгийн хувь хэмжээг салбарын онцлогоос хамааран тогтоох;

33.6.9.ажиллах хүчиний эрэлтийг тодорхойлох, ажил, мэргэжлийн стандарт, мэргэжлийн өөрийн өртгийн тооцооллыг боловсруулах үүрэг бүхий орон тооны бус салбарын зөвлөлийг тухайн асуудлаар мэргэшсэн инженер, техникийн ажилтан, шинжээч, судлаач, сургалтын байгууллагын багш, мэргэжлийн холбоодын оролцоотой нээлттэй шалгаруулалтаар байгуулах, ажиллах журмыг батлах;

33.6.10.салбарын зөвлөлийн боловсруулсан мэргэжлийн өөрийн өртгийн тооцооллыг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

33.6.11.ажлаа Засгийн газарт жил бүр тайлagnах;

33.6.12.хуульд заасан бусад бүрэн эрх.

33.7.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулалт олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

34 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх.

34.1.Төрийн захиргааны төв байгууллага эрхэлсэн салбарын хэрэгцээ, томоохон бүтээн байгуулалтад шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх захиалгыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль нийцүүлэн боловсруулж, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, хамтран ажиллана.

34.2.Тухайн салбарын ажилтны ур чадварын түвшинг хамтран тогтоож болно.

34.3.Ур чадварын тэмцээн, ажил, мэргэжлийн уралдаан зохион байгуулах журмыг тухайн салбарын асуудал эрхэлсэн болон мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

35 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

35.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхтэй:

35.1.1.салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг удирдлагаар хангах;

35.1.2.үндэсний мэргэшлийн тогтолцоо, мэргэшлийн түвшинг мэргэжлийн боловсрол, сургалтын хүрээнд хэрэгжүүлэх;

35.1.3.мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

35.1.4.мэргэжлийн болон техникийн боловсролын талаарх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх санал гаргах;

35.1.5.сургалтын орчныг сайжруулах, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах бодлого, чиглэлийг боловсруулж батлах;

35.1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

36 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

36.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын болон Үндэсний зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байна.

36.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүрэгтэй:

36.2.1.мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

36.2.2.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай санхүүжилтийн гэрээ байгуулах, гүйцэтгэлийн хяналтыг шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийн нэгдсэн сан болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх, үнэлэх, дүгнэх;

36.2.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

36.2.4.сургалт-үйлдвэрлэл, үйлдвэрлэл-сургалтын явцад байгаль орчинд ээлтэй дэвшилтэй техник технологи, шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх, цахим шилжилтийг дэмжих;

36.2.5.мэргэжлийн боловсрол, сургалтын статистик хөтлөх;

36.2.6.мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар шаардлагатай мэдээ тайлан, тооцоо судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

36.2.7.гадаад улсын болон олон улсын ижил төрлийн сургалтын хөтөлбөрөөр төгсөгч, суралцагч Монгол Улсын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцах тохиолдолд боловсролын баримт бичгийг дүйцүүлэх, багц цаг тооцох журам батлах;

36.2.8.мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар гадаад улсын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

36.2.9.хуульд заасан бусад чиг үүрэг.

36.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

37 дугаар зүйл.Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэг

37.1.Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллага дараах чиг үүрэгтэй:

37.1.1.мэргэжлийн боловсрол, сургалтыг арга зүй, удирдлагаар хангах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

37.1.2.судалгаа, шинжилгээ хийх, чадавхыг сайжруулах, зөвлөмжөөр хангах;

37.1.3.сурх бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, түгээх ажлыг зохион байгуулах;

37.1.4.мэргэжлийн боловсрол, сургалтад хөндлөнгийн үнэлгээ хийх, хяналт тавих;

37.1.5.багшийн мэргэшлийн ур чадварын түвшин тогтоох, үнэлгээ хийх;

37.1.6.үнэлгээ, баталгаажуулалтын ажилтныг сонгон шалгаруулах, бэлтгэх, мэргэшүүлэх;

37.1.7.хууль тогтоомжид заасан бусад.

37.2.Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын бүтэц, орон тоо, дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлж, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлаж, дүгнэнэ.

37.4.Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын дэргэд мэргэжлийн чиглэлээр төрөлжсөн орон тооны бус мэргэжлийн зөвлөл байна. Мэргэжлийн зөвлөлийн дүрмийг үнэлгээ арга зүйн асуудал хариуцсан байгууллагын дарга батална.

ДОЛООДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ

38 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын санхүүжилт

38.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын зардлыг сургалтын үр дүн, чанар, гүйцэтгэлд үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

38.2.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

38.3.Мэргэжлийн өөрийн өртгийг тооцох аргачлалыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

38.4.Энэ хуулийн 33.6.10-т заасан дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн өөрийн өртгийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.5.Мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

38.6.Салбар, үйлдвэрлэлийн онцлогоос хамааран аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд цалингийн сангаасаа Үндэсний зөвлөлөөс тогтоосон тодорхой хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

38.7.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийн хуваарийг Үндэсний зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.8.Үнэлгээ, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааны орлого бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

38.9.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх бөгөөд урьдчилсан санхүүжилтийн асуудлыг энэ хуулийн 15.1-д заасан гэрээнд тусгана.

39 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, сангийн орлого, зарлага

39.1.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан гэж энэ хуулийн 39.3-т заасан эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

39.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын дэмжих сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн 38.2-т заасан журмын дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлж, хяналт тавина.

39.3.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

39.3.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

39.3.2.аж ахуйн нэгж, байгууллагын хандив, буцалтгүй тусламж, хуульд заасан санхүүгийн дэмжлэг, гадаад зээл, тусламжийн хөрөнгө;

39.3.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө;

39.3.4.сангийн чөлөөт үлдэгдлийн хүү;

39.3.5.бусад эх үүсвэр.

39.4.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг доор дурдсан зориулалтаар зарцуулна:

39.4.1.өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн гэрээний дагуу олгох зардал;

39.4.2.өмчийн хэлбэр үл харгалзан суралцагчийн дотуур байрын нийт зардал;

39.4.3.өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэг, дэмжлэг;

39.4.4.багш, хүний нөөцийг мэргэшүүлэх сургалт, багшийн ур чадварын түвшин тогтоох, үнэлэх зардал;

39.4.5.ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, түгээх зардал;

39.4.6.мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт боловсруулах зардал;

39.4.7.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын аттестатчилал, гүйцэтгэлийн үнэлгээний зардал;

39.4.8.олон улсын хэмжээний мэргэжлийн ур чадварын тэмцээнд бэлтгэх, оролцох, урамшуулах зардал болон үндэсний хэмжээний мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулах зардал;

39.4.9.Үндэсний зөвлөлийн гишүүний урамшууллын зардал.

39.4.10.бусад зардал;

40 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын төсвийг батлах, тайлан тэнцэл гаргах

40.1.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал батална.

40.2.Үндэсний зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн төсвийн төслийг жил бүрийн 07 дугаар сарын 15-ны дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.

40.3.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын тайлан тэнцлийг доор дурдсан хугацаанд улирал, жилээр нэгтгэн гаргаж, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний зөвлөлд тайлagnаж байна:

40.3.1.мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн улирлын нэгдсэн тайланг дараа улирлын нэг дэх сарын 15-ны дотор, жилийн нэгдсэн тайланг дараа оны 02 дугаар сарын 25-ны дотор тус тус нэгтгэн санал, дүгнэлтийн хамт мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх;

40.3.2.мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улирлын тайланг дараа улирлын сүүлийн сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Үндэсний зөвлөлөөр хянан хэлэлцүүлэх.

40.4.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аudit хийж, дүгнэлт гаргана.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

41 дүгээр зүйл.Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

41.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол албан тушаалтанд Төрийн албаны хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

41.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхул Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

42.1. Энэхүү хуулийг 202 ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР